



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Соёл урлагийн газрын даргын 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: САГ-2026/10/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Улаанбаатар хот

2026 он

Санхүүгийн газрын захирал,

тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг

Утас:261663

Цахим хаяг:naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: И.Эрдэнэцэцэг

Утас:323266

Цахим хаяг:erdenetsetsegi@audit.gov.mn

Ахлах аудитор:

Ш.Наран

Утас:323266

Цахим хаяг: naransh@audit.gov.mn

Аудитор:

Т.Нямсүрэн

Утас:323266

Цахим хаяг: nyamsurent@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ..	7
2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан	7
2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан	7
2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	9
2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	12
3. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	14
3.1 Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүний үйл ажиллагаа.....	14
3.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн гадаад, дотоод орчин.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	25
4.1 Ерөнхий зүйл	25
4.2 Материаллаг байдал.....	25
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	25
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	25
4.4.2.2. Төсвийн төвлөрүүлэн захирагч.....	27
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	28
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	29
5.1 Төсвийн төвлөрүүлэн захирагч	30
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ.....	32

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ССАЖЗС	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд
ССАЖЗЯ	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам
СУГ	Соёл урлагийн газар



**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

СОЁЛ УРЛАГИЙН ГАЗРЫН ДАРГЫН
АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Г.БАТХУЯГ ТАНАА

2026.03.25 № 789
танай _____-ны № _____-т
Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Соёл урлагийн газрын даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу аудит хийгдэх байгууллагаас хараат бусаар гүйцэтгэж, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний олж авсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Соёл урлагийн газрын даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар илэрсэн нийт 6,057.9 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд шинж чанарын хувьд материаллаг, дангаараа буюу нийт дүнгээрээ санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй байна. Тухайлбал:

- Харьяа байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн тодруулга, тайлбар, төсвийн гүйцэтгэлийн тайлангийн иж бүрдлийг хангаж ирүүлээгүй;
- Соёл урлагийн газрын даргын эрхлэх асуудлын хүрээний харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүйгээс тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6,057.9 сая төгрөгийн зөрчил илэрсэн;
- Соёл, урлагийн салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүргийг улсын хэмжээнд зохион байгуулах ажлын хүрээнд нийт 7 хууль тогтоомжийг дагалдан гаргах 65 журмаас 33 журам баталж, 32 журмыг батлаагүй, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход харьяа, анхан шатны байгууллагаас санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй, хяналт, хариуцлагын үр нөлөө бүхий тогтолцоо бүрдээгүй;

- Соёлын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлд хяналт-шинжилгээ хийдэггүй, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг дээд шатны зорилтод түвшинд нийцүүлээгүй, төлөвлөлтийг бодлогын баримт бичигт чиглүүлээгүй, мөн төлөвлөсөн арга хэмжээ нь харилцан адилгүй, уялдаа холбоогүй ялгаатай байгаа нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа нэгдсэн удирдлагаар хангаж ажилладаггүй.

Дээрх зөрчлүүд нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1, 15 дугаар зүйлийн 15.4, 15.4.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.5 дахь заалтуудтай тус тус нийцээгүй, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 24-ийг мөрдөөгүй, санхүүгийн тайлангийн нийцсэн бөгөөд зохистой байх, оршин байх, эрх ба үүрэг, үнэлгээ ба хуваарилалт батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газраас 2023-2025 оныг “Монголд зочлох жил” болгон зарласантай холбогдуулан Соёлын биет бус өвийн төрөл зүйлийг сурталчлах, түгээн дэлгэрүүлэх, Монголчуудын уламжлалт сар шинийн баяр, түүнтэй холбоотой зан үйл, ёс заншлыг сурталчлан таниулах “МОНГОЛ” нүүдэлчин өвлийн фестивалийг 2025 оны 02 дугаар сарын 16-ны өдрөөс 22-ны өдрүүдэд “Үндэсний цэцэрлэгт хүрээлэн”-д анх удаа амжилттай зохион байгуулсан.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор “Үндэсний бичиг соёл, номын өдрүүд”-ийг хавар, намар 2 удаа зохион байгуулж, улсын хэмжээнд 150 орчим номын худалдаа эрхлэгч, 98 мянга гаруй уншигч, 400 орчим шилдэг хэвлэн нийтлэгч, зохиолч яруу найрагч, 290 орчим аж ахуйн нэгж байгууллагууд давхардсан тоогоор 1500 гаруй арга хэмжээнд нийт 670 мянга гаруй иргэн хамрагдсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Бүгд Найрамдах Франц Улсын хууль сахиулах байгууллагаас 2013, 2015 онд хураасан үлэг гүрвэлийн чулуужсан олдворыг Монгол Улсад үнэ төлбөргүй хүлээлцэх актад гарын үсэг зурах ёслолын арга хэмжээ 2025 оны 12 дугаар сарын 08-ны өдөр Парис хотноо зохион байгуулагдаж, эдгээр олдворууд нь Монгол Улсын говиос олддог үлэг гүрвэлийн чулуужсан олдвор болох нь тогтоогдсон бөгөөд Монгол Улсад хүлээлгэн өгч байгаа 29 багц олдвор дунд 70-65 сая жилийн тэртээ Монголын говиор амьдарч байсан тарбозаврбатаар, теропод, орнитомимозавр, гидрозавр зэрэг шинжлэх ухааны нэн өндөр ач холбогдолтой үлэг гүрвэлийн чулуужсан ясны хэсгүүд байгаа болохыг шинжээчид дүгнэсэн байна.

Бусад асуудал

Төрийн аудитын байгууллага нь төсөвт байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандартын дагуу хууль, тогтоомжийн хэрэгжилтэд нэмэлт горим, сорил гүйцэтгэх үүрэг хүлээдэг.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн нэгтгэсэн тайланд төсвийн төвлөрүүлэн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд Аудитын дээд байгууллагын олон улсын стандартын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.



С.МАГНАЙСҮРЭН

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		26,571,435.2	29,588,124.7
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	3а, 3б	480,057.3	1,842.3
33	АВЛАГА	5а, 5б, 6а,	739,162.4	1,238,637.5
34	УРЬДЧИЛГАА	7а, 7б	72,380.0	34,668.1
35	БАРАА МАТЕРИАЛ	8а, 8б, 8в	25,279,784.4	28,304,009.7
36	НӨӨЦИЙН БАРАА		51.2	-
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ		-	8,967.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН		469,574,264.2	542,215,819.8
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	12а, 12б,	469,574,264.2	542,215,819.8
39300	Биет бус хөрөнгө		451,995,445.7	524,090,407.4
39303	Бусад биет бус хөрөнгө	13	17,578,818.5	18,125,412.4
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2		496,145,699.4	571,803,944.4
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР		449,606.1	1,176,371.1
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР		449,606.1	1,176,371.1
41300	Өглөг		449,606.1	1,176,371.1
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН		495,696,093.4	570,627,573.3
51	Засгийн газрын хувь оролцоо		495,696,093.4	570,627,573.3
51100	Засгийн газрын оруулсан капитал		114,265,301.6	114,228,862.1
51200	Хуримтлагдсан үр дүн		271,780,231.3	348,874,559.2
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү		109,650,560.5	107,524,152.0
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5		496,145,699.4	571,803,944.4

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Тайлангийн үзүүлэлт	Тодруулга	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН		259,706,655.2	286,569,108.6
11	ТАТВАРЫН ОРЛОГО			203,521.0
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1а, 1б	78,735,426.9	286,365,587.6
120	Нийтлэг татварын бус орлого		78,621,876.3	105,784,879.1
122	Тусламжийн орлого		113,550.7	179,837,504.2
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО		180,971,228.3	
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2а, 2б	205,053,733.5	209,501,897.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ		205,050,974.5	209,456,008.6
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		180,337,814.6	200,023,432.2
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		111,891,794.3	129,917,128.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		13,962,179.7	16,010,519.8
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		439,733.4	959,629.6
2104	Хангамж, бараа материалын зардал		4,330,801.2	3,666,781.2
2105	Норматив зардал		95,830.3	34,292.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		805,572.0	699,769.5
2107	Томилолт, зочны зардал		1,272,449.0	718,465.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		23,120,798.4	10,729,158.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал		24,418,656.3	37,287,687.3
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		24,713,159.8	9,432,576.4
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		2,759.0	45,888.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)		54,652,921.8	77,067,211.3
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		(3,349,651.6)	(2,528,537.8)
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(V)		51,352,231.8	74,538,673.5

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	114,087,298.4	-	443,371,719.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(60,884.2)	-	1,127,253.4
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	114,026,414.2	-	444,498,972.6
Тайлант үеийн үр дүн	238,887.4		51,197,120.8
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	114,265,301.6	-	495,696,093.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(155,912.4)	-	392,806.5
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	114,109,389.2	-	497,278,092.1
Тайлант үеийн үр дүн	119,473.0		74,538,673.5
2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	114,228,862.2	-	570,627,573.3

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

код	Тайлангийн үзүүлэлт	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	189,823,435.1	187,167,384.7
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	9,561,338.4	187,167,384.7
120	Нийтлэг татварын бус орлого	9,546,338.4	8,190,789.8
122	Тусламжийн орлого	15,000.0	178,713,839.4
122	Хандив тусламж		262,755.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	180,262,096.8	
1311	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	188,991,937.0	184,134,218.0
II	УРСГАЛ ЗАРДАЛ	188,991,937.0	184,134,218.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	163,960,479.6	173,995,000.3
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	111,961,235.8	129,756,112.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	13,961,496.5	15,971,139.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	339,040.8	574,922.6
2104	Хангамж, бараа материалын зардал	3,141,407.2	1,953,385.4
2105	Норматив зардал	168,720.6	36,826.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,441,773.3	1,785,423.8
2107	Томилолт, зочны зардал	1,316,602.1	686,049.2
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	26,122,292.0	11,493,632.9
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,507,911.3	11,737,508.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	25,031,457.4	10,139,217.7
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	831,498.1	3,033,166.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	8,047,361.1	3,493,165.2
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(8,047,361.1)	(3,493,165.2)
VII	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	(21.0)	(18,216.4)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(7,215,884.0)	(478,214.9)
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	7,695,941.3	480,057.3
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	480,057.3	1,842.3
99	Хамаарахгүй	-	-
100	Тохируулгын орлого, зарлагын зөрүү	-	104.2

2.5 Аудит хийсэн нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	175,094,692,900.00	169,156,284,257.57	5,938,408,642.43	96.61
12	Татварын бус орлого	175,094,692,900.00	169,156,284,257.57	5,938,408,642.43	96.61
120	Нийтлэг татварын бус орлого	8,454,020,300.00	7,930,765,884.77	523,254,415.23	93.81
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого /үндсэн/	4,950,967,100.00	4,544,367,609.70	406,599,490.30	91.79
120010	Төсөв байгууллагын өөрийн орлого /туслах/	3,503,053,200.00	3,386,398,275.07	116,654,924.93	96.67
122	Тусламжийн орлого	166,640,672,600.00	161,225,518,372.80	5,415,154,227.20	96.75
122005	Төсвөөс санхүүжих	166,640,672,600.00	161,225,518,372.80	5,415,154,227.20	96.75
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	175,094,692,900.00	167,969,049,016.75	7,125,643,883.25	95.93
21	УРСГАЛ ЗАРДАЛ	175,094,692,900.00	167,969,049,016.75	7,125,643,883.25	95.93
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	169,861,224,000.00	163,203,777,529.63	6,657,446,470.37	96.08
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	131,499,749,800.00	128,817,887,407.23	2,681,862,392.77	97.96
210101	Үндсэн цалин	77,054,302,600.00	77,305,604,568.98	77,305,604,568.98	100.33
210102	Нэмэгдэл	42,415,833,500.00	39,788,856,615.46	39,788,856,615.46	93.81
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,246,499,700.00	3,829,995,914.53	3,829,995,914.53	117.97
210104	Урамшуулал	8,765,914,000.00	7,878,404,366.38	7,878,404,366.38	89.88
210105	Гэрээт ажлын хөлс	17,200,000.00	15,025,941.88	15,025,941.88	87.36
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	16,440,829,200.00	15,862,537,058.12	578,292,141.88	96.48
210201	Тэтгэврийн даатгал	11,249,209,200.00	10,889,181,016.79	360,028,183.21	96.80
210202	Тэтгэмжийн даатгал	1,297,994,900.00	1,260,680,922.06	37,313,977.94	97.13
210203	ҮОМШӨ-ний даатгал	649,235,500.00	645,820,843.62	3,414,656.38	99.47
210204	Ажилгүйдлийн даатгал	648,939,000.00	615,700,236.90	33,238,763.10	94.88
210205	Эрүүл мэндийн даатгал	2,595,450,600.00	2,451,154,038.75	144,296,561.25	94.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	336,114,900.00	306,438,448.76	29,676,451.24	91.17
210301	Гэрэл, цахилгаан	25,832,900.00	27,183,085.07	(1,350,185.07)	105.23
210302	Түлш, халаалт	94,809,700.00	91,724,601.99	3,085,098.01	96.75
210303	Цэвэр, бохир ус	18,076,800.00	16,473,061.70	1,603,738.30	91.13
210304	Байрны түрээс	197,395,500.00	171,057,700.00	26,337,800.00	86.66
2104	Хангамж, бараа материалын зардал	2,121,221,300.00	1,834,804,646.82	286,416,653.18	86.50
210401	Бичиг хэрэг	446,138,700.00	326,596,463.00	119,542,237.00	73.21
210402	Тээвэр, шатахуун	529,154,600.00	510,004,089.89	19,150,510.11	96.38
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	499,949,100.00	401,707,270.52	98,241,829.48	80.35
210404	Ном, хэвлэл	124,750,800.00	111,130,513.00	13,620,287.00	89.08
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	11,101,300.00	10,564,844.00	536,456.00	95.17
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	510,126,800.00	474,801,466.41	35,325,333.59	93.08
2105	Норматив зардал	45,348,300.00	30,126,181.00	15,222,119.00	66.43

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	45,348,300.00	30,126,181.00	15,222,119.00	66.43
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,727,524,900.00	4,483,697,455.40	243,827,444.60	94.84
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,631,988,200.00	3,481,570,981.60	150,417,218.40	95.86
210602	Тавилга	751,005,100.00	683,383,799.99	67,621,300.01	91.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	13,200,000.00	3,713,000.00	9,487,000.00	28.13
210604	Урсгал засвар	331,331,600.00	315,029,673.81	16,301,926.19	95.08
2107	Томилолт, зочны зардал	789,408,800.00	620,578,690.00	168,830,110.00	78.61
210702	Дотоод албан томилолт	789,408,800.00	620,578,690.00	168,830,110.00	78.61
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	6,234,208,000.00	4,000,878,849.44	2,233,329,150.56	64.18
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,043,262,600.00	3,895,588,007.04	2,147,674,592.96	64.46
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	123,614,200.00	60,756,968.00	62,857,232.00	49.15
210803	Даатгалын үйлчилгээ	6,575,200.00	4,741,102.40	1,834,097.60	72.11
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,451,200.00	2,290,747.00	2,160,453.00	51.46
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	2,768,000.00	787,026.00	1,980,974.00	28.43
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	13,403,400.00	6,124,500.00	7,278,900.00	45.69
210807	Газрын төлбөр	38,283,400.00	29,440,869.00	8,842,531.00	76.90
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,850,000.00	1,149,630.00	700,370.00	62.14
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,666,818,800.00	7,246,828,792.86	419,990,007.14	94.52
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	7,616,701,900.00	7,197,002,152.86	419,699,747.14	94.49
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	50,116,900.00	49,826,640.00	290,260.00	99.42
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	5,233,468,900.00	4,765,271,487.12	468,197,412.88	91.05
2132	Бусад урсгал шилжүүлэг	5,233,468,900.00	4,765,271,487.12	468,197,412.88	91.05
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	869,679,300.00	806,975,218.00	62,704,082.00	92.79
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	91,800,000.00	91,800,000.00	0.00	100.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	2,649,045,500.00	2,498,497,374.12	150,548,125.88	94.32
213208	Хөдөө орон нутаг тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	1,052,110,300.00	881,053,882.00	171,056,418.00	83.74
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	570,833,800.00	486,945,013.00	83,888,787.00	85.30
8	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	-	325,031,058.80	(325,031,058.80)	-
9	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	325,031,058.80	(325,031,058.80)	-
7	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	-	325,031,058.80	(325,031,058.80)	-

4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	426	426	-	100.00
610001	Төсвийн байгууллага	426	426	-	100.00
610002	Төсвөөс гадуур байгууллага	-	-	-	-
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	4669	4718	49	101.00
620001	Удирдах ажилтан	426	426	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	3178	3202	24	100.80
620003	Үйлчлэх ажилтан	1067	1090	23	102.20
620004	Гэрээт ажилтан	-	-	-	-

2.6 Аудит хийсэн нэгтгэсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Хугацаа: 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ төгрөгөөр/

Дансны код	Дансны нэр, төрөл	Тайлант он
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	14,343,818,508.09
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	14,343,818,508.09
122	Тусламжийн орлого	14,343,818,508.09
1221	Хандив тусламж /дотоод/	14,343,818,508.09
12213	Нэмэлт санхүүжилтийн орлого	14,343,818,508.09
350013	ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	3,285,651,714.14
350014	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,996,193,617.94
350015	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	61,973,176.01
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	14,160,226,978.95
21	УРСГАЛ ЗАРДАЛ	14,160,226,978.95
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	13,864,885,478.95
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	922,577,575.75
210101	Үндсэн цалин	285,285,754.60
210102	Нэмэгдэл	477,404,632.70
210103	Унаа хоолны хөнгөлөлт	22,988,170.95
210104	Урамшуулал	136,899,017.50
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	108,679,135.11
210201	Тэтгэврийн даатгал	95,459,788.62
210202	Тэтгэмжийн даатгал	3,520,839.12
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,797,851.85
210204	Ажилгүйдлийн даатгал	1,513,987.51
210205	Эрүүл мэндийн даатгал	6,386,668.01
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	18,979,294.89
210301	Гэрэл, цахилгаан	6,339,062.90
210302	Түлш, халаалт	9,544,767.18
210303	Цэвэр, бохир ус	3,095,464.81
2104	Хангамж, бараа материалын зардал	193,498,910.00
210401	Бичиг хэрэг	3,322,500.00
210402	Тээвэр, шатахуун	144,122,590.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	660,550.00
210404	Ном, хэвлэл	12,475,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	32,918,270.00
2105	Норматив зардал	13,240,000.00
210502	Хоол, хүнс	13,240,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,465,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,949,800.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	284,000.00
210604	Урсгал засвар	15,231,500.00
2107	Томиллолт, зочны зардал	65,470,510.00
210702	Дотоод албан томиллолт	65,470,510.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,855,582,356.20
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,854,551,013.20
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	313,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	718,343.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,666,392,397.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,457,459,254.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	208,933,143.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	295,341,500.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	295,341,500.00

213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	295,341,500.00
4	ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН НИЙТ ТЭНЦЭЛ	183,591,529.14
5	АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	(183,591,529.14)
6	Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	(183,591,529.14)

3. САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Төсвийн төвлөрүүлэн захирагч, түүний үйл ажиллагаа

Соёл, урлагийн газар нь соёл, урлагийн салбарын хууль тогтоомж, бодлого, стратегийг хэрэгжүүлэх үүрэг, хариуцлагыг хүлээж, соёлын асуудал эрхэлсэн сайдад мэргэжлийн зөвлөгөө, бүх талын дэмжлэг үзүүлж, хариуцсан чиг үүргийн дагуу иргэд, олон нийтэд шуурхай, мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллага бөгөөд Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн төвлөрүүлэн захирагчийг шинэчлэн батлах тухай” 2024 оны 110 дугаар тогтоолоор Соёл, урлагийн газрын дарга нь Соёл, урлагийн газар, орон нутгийн гүйцэтгэл, үр дүнгийн санхүүжих соёлын байгууллагуудын төсвийн төвлөрүүлэн захирагч, засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг юм.

Соёл, урлагийн газрын тайлант оны эрхэм зорилгоо “Соёл, урлаг, утга зохиолыг хөгжүүлэх, түүх, соёлын өвийг хамгаалах, соёлын бүтээлч үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих замаар салбарын нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлж, тогтвортой хөгжлийг хангахад оршино” гэж тодорхойлсон бөгөөд үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийг дараах байдлаар баталжээ. Үүнд:

- Соёл, урлаг, утга зохиолын төрөл зүйлийг жигд хөгжүүлэх, дэмжлэг үзүүлэх, чанартай, хүртээмжтэй, соёлын үйлчилгээг иргэдэд хүргэх, соёл, урлагийн боловсрол олгох, сурталчлах бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;
- Түүх, соёлын өвийг хамгаалах, хадгалах, өвлүүлэн уламжлуулах, эрэн сурвалжлах, устгах, эвдрэх, гэмтэх аюул, учирсан соёлын өвийг авран хамгаалах, сэргээн засварлах, урьдчилан сэргийлэх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах;
- Соёлын бүтээлч үйлдвэрлэл, үйлчилгээг дэмжих соёлын илэрхийллийн олон төрлийг хамгаалах, түгээн дэлгэрүүлэх бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах.

Тайлант жил үйл ажиллагааны тэргүүлэх 7 чиглэл, эрхэм зорилгын хүрээнд хэрэгжүүлэх стратегийн 174 зорилт тавьж, 1137 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, баталсан байна. Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам Соёл, урлагийн газрын даргын эрхлэх асуудлаар тусгасан 10 зорилтын хүрээнд 74 арга хэмжээний хэрэгжилтийг 94.0 хувиар тайлагнасан байна.

3.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн гадаад, дотоод орчин

Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Хувь хүний мэдээлэл хамгаалах тухай хууль, Соёлын тухай хууль, Соёлын өвийг хамгаалах тухай хууль, Соёлын бүтээлч үйлдвэрийг дэмжих тухай хууль, Номын сангийн тухай хууль, Музейн тухай хууль, Аялал жуулчлалын тухай хууль, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хууль, Монгол хэлний тухай хууль, Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, Үндэсний их баяр наадмын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Оюуны өмчийн тухай хууль, Зохиогчийн эрхийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд чиг үүргээ хэрэгжүүлэн ажиллаж байна.

Тайлант хугацаанд төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт;
- Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дүгээр “Төрийн албаны зарим албан тушаалын цалингийн хэмжээ, доод хэмжээг шинэчлэн тогтоох тухай” тогтоол;

- Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 08 дугаар сарын 20-ны өдрийн 52 дугаар “Засгийн газрын агентлагийн бүтэц орон тооны талаар хэрэгжүүлэх арга хэмжээний тухай” тогтоол;
- Үндэсний баяр наадмын тухай хуульд өөрчлөлт;

Удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсэн дүн шинжилгээний үр дүнд дотоод дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Соёл, урлагийн газрын хяналт-шинжилгээ, үнэлгээ, салбарын хяналтын хэлтсийн чиг үүрэг, хэрэгжүүлсэн ажлын талаар хангалттай ойлголт олж авсны үндсэн дээр дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн нэгтгэсэн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн нэгтгэсэн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Соёл, урлагийн газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Соёл, урлагийн газрын төсвийн төвлөрүүлэн захирагч нь соёлын салбарын үйл ажиллагааны онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөж ажиллаагүй байна.

Нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5-д заасан бүрэлдэхүүн хэсгийн дагуу бүрэн бэлтгээгүй бөгөөд аудитын явцад залруулсан.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Соёл, урлагийн газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тус төсвийн төвлөрүүлэн захирагч нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохируулан боловсруулаагүй боловч дээд шатны төсөв захирагчийн Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, үйл ажиллагааны онцлогт тохирсон байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй.

Тайлант оны санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар өмнөх оноос 75,658.2 сая төгрөгөөр буюу 15.2 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	480,057.3	1,842.3	(478,215)
Авлага	739,162.4	1,238,637.5	499,475.1
Урьдчилгаа	72,380.0	34,668.1	(37,711.9)
Бараа материал	25,279,784.4	28,304,009.7	3,024,225.3
Нөөцийн бараа	51.2	0	(51.2)
Үндсэн хөрөнгө	469,574,264.2	542,215,819.8	72,641,555.6
Нийт хөрөнгийн дүн	496,145,699.4	571,803,944.4	75,658,245.0

Нийт өр төлбөр	449,606.1	1,176,371.1	726,765.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	495,696,093.4	570,627,573.3	74,931,479.9
Өр төлбөр, цэвэр хөрөнгө өмчийн дүн	496,145,699.4	571,803,944.4	75,658,245.0

Эх сурвалж: Төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан

Дээрх хүснэгтээс харахад, өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөр, засгийн газрын хувь оролцоо /эздийн өмч/ данс байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 1.8 сая төгрөг болж өмнөх оноос 478.2 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Кассын бэлэн мөнгө	-	-	-
Төрийн сангийн харилцах	477,237.2	1,500.0	(475,737.1)
Арилжааны банк дахь харилцах	-	342.3	342.3
Бусад төсөл, нөөцийн харилцах	2,814.8	-	(2,814.8)
Нэмэлт санхүүжилтийн харилцах	5.3	-	(5.3)
Дүн	480,057.3	1,842.3	(478,214.9)

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь өмнөх тайлант оны эцэстэй харьцуулахад 478,214.9 сая төгрөгөөр буурч, жилийн эцсийн дансны үлдэгдэл 1.8 сая төгрөг байна. Үүнд: Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь барьцаа хөрөнгийн дансанд Засгийн газрын 2021 оны 397 дугаар тогтоол, 2022 оны 495 дугаар тогтоол, 2023 оны 497 тогтоол, 2024 оны 249 дүгээр тогтоолоор тус тус байршуулсан Нийслэлийн соёл урлагийн газрын чанарын баталгааны барьцааны 1.5 сая төгрөг, Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын соёлын төв 0.3 сая төгрөг тус тус байна.

Харьяа байгууллагуудын илрүүлэлт:

- Албан хаагчдын цалин, урамшууллын тооцооллыг 2,5 сая төгрөгөөр илүү тооцож олгосон./Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян багийн соёлын төв 0.2 сая төгрөг, Өмнөговь аймгийн Сэврэй сумын Соёлын төв 0.3 сая төгрөг, Сүхбаатар аймгийн Дарьганга сумын Соёлын төв 1.0 сая төгрөг, Мөнххаан сумын Соёлын төв 0.4 сая төгрөг, Сүхбаатар сум сумын Соёлын төв 0.3 сая төгрөг, Төв аймгийн Алтанбулаг сумын Соёлын төв 0.1 сая төгрөг, Лүн сумын Соёлын төв 0.8 сая төгрөг, Гурванбулаг сумын Соёлын төв 1.5 сая төгрөг/;
- Анхан шатны баримтын бүрдэл дутуу баримттай 37.0 сая төгрөгийн ажил гүйлгээг хийсэн./Хэнтий аймгийн Дархан сумын Соёлын төв 6.7 сая төгрөг, Гурванбаян тосгоны соёлын төв 3.8 сая төгрөг, Төв аймгийн Эрдэнэ сумын Соёлын төв 1.4 сая төгрөг, Сүхбаатар аймгийн Соёл, урлагийн газар 0.5 сая төгрөг, Өмнөговь аймгийн Цогтцэций сумын Соёлын төв 23.0 сая төгрөг, Хүрмэн сумын Соёлын төв 1.7 сая төгрөг/;
- Түлш халаалтын зардлаас албан хаагчдад түлээ, нүүрсний хөнгөлөлт олгосон. /Булган аймгийн Гурванбулаг сумын Соёлын төв 0.2 сая төгрөг, Сүхбаатар аймгийн Уулбаян сумын Соёлын төв 0.8 сая төгрөг, Хэнтий аймгийн Галшар сумын соёлын төв 0.2 сая төгрөг/;
- Мал аж ахуйгаас орох орлогын тооцоог төлөвлөөгүй, төсөв байгууллагын өөрийн орлогыг төсвийн дансанд төвлөрүүлээгүй. /Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театр 2.6 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Мандал сумын Хэрх тосгоны соёлын төв 3.4 сая төгрөг, Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян багийн соёлын төв 2.5 сая төгрөг, Говь-Алтай аймгийн Орон нутгийг судлах музей, Дорнод аймгийн музей /;
- Бараа үйлчилгээний бусад зардлаас ажлын зураг төсөв хийх, төмөр шүүгээ, тарьц мод, сэлбэг хэрэгсэл, мотор, хулдаас зэргийг худалдан авах, бүжгийн багш, дууны багшийн ажлын хөлс

шилжүүлэхдээ гэрээ байгуулаагүй. /Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Соёлын төв 12.6 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Мандал сумын дуу бүжгийн чуулга 1.7 сая төгрөг, Төв аймгийн музей 9.0 сая төгрөг/;

- Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлаас өргөмжлөл, хүүхдийн бэлэг, дугуйн уралдаанд зарцуулсан, тэмцээний шагналын зардлыг нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас гаргасан. /Өмнөговь аймгийн Мандал-Овоо сумын Соёлын төв 2.5 сая төгрөг, Сүхбаатар аймгийн Халзан сумын Соёлын төв 0.3 сая төгрөг/;
- Төв аймгийн Цээл сумын Соёлын төв албан хаагчдад 0.9 сая төгрөгийн ажлын хувцас худалдан авсан;
- Байгууллагын нягтлан бодогчийн батлагдсан орон тоо нь 0.5-аар батлагдсан бөгөөд албан хаагчтай байгуулсан гэрээ, тушаал шийдвэрээр албан тушаалын сарын цалинг нягтлан бодогчийн /ТҮМ-7/ үндсэн цалингийн 50.0 хувиар тогтоосон боловч үр дүнгийн урамшууллыг үндсэн цалингаас тооцож олгосон;
- Соёл урлагийн газар нь Монгол Улсыг "Go Mongolia" урианы дор олон улсад сурталчлан таниулах чиглэлээр зохион байгуулсан "Монгол" нүүдэлчин өвлийн фестиваль, Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулахтай холбоотой 79 байгууллага, 35 хувь хүнтэй хэвлэл, тохижилт, түрээс, тээвэр зэрэг ижил төрлийн ажил үйлчилгээг нээлттэй тендер сонгон шалгаруулалтгүйгээр, төсөвт өртгийн дээд хязгаарт багтаан хувааж, 1,438.2 сая төгрөгийн бараа, ажил, үйлчилгээг худалдан авсан;
- Соёл урлагийн газрын даргын 2025 оны А/46 дугаартай тушаалаар "Нүүдэлчин" дэлхийн соёлын фестивалийг зохион байгуулахад харьяа аймаг, орон нутгийн газруудад 264.7 сая төгрөг, дүрс бичлэг хийлгүүлэх 10.0 сая төгрөг, нийт 274.7 сая төгрөгийг олгож, гүйцэтгэсэн ажлын тайлан хангалтгүй, тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллаагүй, дотоод хяналт сул байна.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 1,238.6 сая төгрөг болж өмнөх оноос 499.5 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+) Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Ажиллагчидтай холбогдсон авлага	125,516.7	69,249.8	(56,266.9)
Төлбөртэй үйлчилгээний авлага	30,714.6	37,126.0	6,411.4
Татаас, санхүүжилтийн авлага	284,603.7	823,731.8	539,128.1
Дансны авлага /ТӨҮГ/	-	-	-
Татвар, НДШ-ын авлага /ТӨҮГ/	2,260.6	0.0	(2,260.6)
Байгууллагаас авах авлага	142,824.7	136,559.7	(6,265.0)
Хувь хүмүүсээс авах авлага	153,242.2	171,970.2	18,728.0
Дүн	739,162.4	1,238,637.5	499,475.1

Авлага дансны үлдэгдэл өсөхөд татаас санхүүжилтийн 823.7 сая төгрөгийн авлага нөлөөлсөн байна.

Харьяа байгууллагуудын илрүүлэлт:

- Авлагын дансны үлдэгдлийг тооцоо нийлж тулган баталгаажуулаагүй. /Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музей 1.2 сая төгрөг, Дархан-Уул аймгийн залуучууд театр 4.0 сая төгрөг/;
- Тайлан оны санхүүгийн тайлант цалин, нийгмийн даатгалын шимтгэлтэй холбоотой шинээр үүссэн авлагыг тусгаж тайлагнаагүй. /Ховд аймгийн Зэрэг сумын соёлын төв 0.1 сая төгрөг, Төв аймгийн Заамар сумын Соёлын төв 0.5 сая төгрөг, Төв аймгийн музей 9.0 сая төгрөг, Хөвсгөл аймгийн нийтийн номын сан 1.6 сая төгрөг/;
- Төсөв байгууллагын өөрийн орлого бүрдүүлэлтэд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сул байгаагаас тайлант онд авлага үүсгэсэн. /Төв аймгийн Борнуур сумын Соёлын төв 6.6 сая төгрөг, Булган аймгийн Рашаант сумын Соёлын төв 0.3 сая төгрөг/;

- Олон жил болсон насжилт өндөр, он дамжсан данс бүртгэлд тусгасан авлагыг барагдуулаагүй. /Тайшир сумын Соёлын төв 0.5 сая төгрөг, Жаргалант сумын Соёлын төв 0.2 сая төгрөг, Дархан-Уул аймгийн залуучууд театр 4.3 сая төгрөг/;
- Удирдлагын буруутай шийдвэрээс болж ажлаас халагдсан ажилтанд шүүхийн шийдвэрээр цалингийн нөхөн олговрыг олгосон бөгөөд буруутай этгээдээс нэхэмжлээгүй байгууллагын төсвөөс төлсөн. /Ховд аймгийн хөгжимт драмын театр 6.0 сая төгрөг, Бигэр сумын Соёлын төв 2.4 сая төгрөг/.

3.4.3 Урьдчилгаа

Урьдчилгаа дансны эцсийн үлдэгдэл 34.7 сая төгрөг болж өмнөх оноос 37.7 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Урьдчилж гарсан зардал	64,680.0	34,668.1	(30,011.9)
Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	7,500.0	0	(7,500.0)
Цалингийн урьдчилгаа	200.0	0	(200.0)
Томилолтын урьдчилгаа	0	0	0
Дүн	72,380.0	34,668.1	(37,711.9)

Өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан урьдчилж гарсан зардал 30.0 сая төгрөг, үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа 7.5 сая төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна. Үүнд: Нийслэлийн Соёл, урлаг, аялал жуулчлалын газрын 27.0 сая төгрөг, Хэнтий аймгийн Норовлин соёлын төв 1.5 сая төгрөг, Орон нутгийн номын сан 1.5 сая төгрөг тус тус үлдэгдэлтэй байна.

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 28,304.0 сая төгрөг болж өмнөх оноос 3,024.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Түүхий эд материал	5,881,491.5	7,158,517.0	1,277,025.5
Хангамжийн материал	18,580,911.4	20,604,459.9	2,023,548.5
Биологийн хөрөнгө	13,319.7	13,419.6	100.0
Мал амьтад	38,965.0	62,535.0	23,570.0
Бэлэн бүтээгдэхүүн	758,427.1	465,078.0	(293,349.1)
Дуусаагүй үйлдвэрлэл	6,669.6	0	(6,669.6)
Дүн	25,279,784.4	28,304,009.7	3,024,225.3

Дээрх хүснэгтээс харахад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан бараа материалын өсөлтөд хангамжийн материал 2,023.5 сая төгрөг, түүхий эд материал 1,277.0 сая төгрөг, мал амьтад 23.5 сая төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн.

Харьяа байгууллагуудын илрүүлэлт:

- Нийслэлийн Соёл урлагийн газар нь Нийслэлийн засаг даргын тамгын газраас Үндэсний их баяр наадмыг зохион байгуулах зардлаас гарсан 585.1 сая төгрөгийн бараа материал шилжүүлэн авсан боловч байгууллагад биетээрээ ирээгүй, бараа материал хүлээлцсэн акт үйлдээгүй, 177.1 сая төгрөгийн бараа материалын тайланг материалын нэр төрөл, тоо хэмжээгээр нэгтгэн гаргадаггүй, төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлийг төвлөрүүлэлгүй 1.0 сая төгрөгийн түлээ нүүрсийг худалдан авч нөөцөлсөн;

- Материалын тайланд жилийн эцсийн тооллогыг үнэн зөв, чанартай хийгээгүй. /Булган аймгийн Хишиг-Өндөр сумын Соёлын төв 1.9 сая төгрөг, Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Соёлын төв 6.8 сая төгрөг, Ховд аймгийн Мөст сумын соёлын төв 7.2 сая төгрөг/
- Бараа материалын тайланд орлого, зарлагын баримт, шаардах хуудас дутуу хөтөлсөн. /Өвөрхангай аймгийн Бат-Өлзий сумын Соёлын төв 4.4 сая төгрөг, Гучин-Ус сумын Соёлын төв, Хайрхан дулаан сумын Соёлын төв/
- Шатахууны замын хуудас бөглөөгүй, тооцоо хийгээгүй. /Төв аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлалын газар 3.2 сая төгрөг, Эрдэнэ сумын Соёлын төв 0.4 сая төгрөг, Дархан-Уул аймгийн Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар 2.0 сая төгрөг, Орхон аймгийн соёл урлагийн газар, Орхон аймгийн хүүхэд залуучуудын театр 1.2 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар 2.5 сая төгрөг/
- Соёлын төвийн өрөө тасалгааг засуулахаар гэрээ байгуулан санхүүжилт, бараа материалыг нь олгосон боловч тайлант ондоо багтааж засварын ажлаа хийж, хүлээлгэж өгөөгүй. /Төв аймгийн Дэлгэрхаан сумын Соёлын төв 4.0 сая төгрөг, Ховд аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар/
- Баян-Өлгий аймгийн Булган сумын соёлын төвийн бараа материалын тайлан дахь эхний үлдэгдэл, нярвын хөрөнгийн тайлангийн эхний үлдэгдэл 1.5 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Баянхонгор аймгийн Түүх угсаатны зүйн музейн шатахууны тайланд биетээр байхгүй 2.3 сая төгрөгийн шатахуун бүртгэлтэй;
- Булган аймгийн Тэшиг сумын Соёлын төвийн аж ахуйн материал дансанд 3.0 сая төгрөгийн үнэтэй соёлын өв болох тоглолтын 6 нэр төрлийн хувцас материал хэлбэрээр бүртгэлтэй;
- Төв аймгийн Сүмбэр сумын Соёлын төв номын сангийн уншлагын танхимд 0.9 сая төгрөгийн 4 ширхэг хөшгийг нийлүүлэгчийн нэр, мөнгөн дүн зөрүүтэй орлогод авч буцаан зарлагадсан;
- Дорноговь аймгийн Сайншанд сумын Зүүнбаян багийн соёлын төвийн аж ахуйн материал дансанд 105 нэр төрлийн 27.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн шинж чанартай хөрөнгө байна.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 571,803.9 сая төгрөг болж өмнөх оноо 75,658.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Биет хөрөнгө	451,995,445.7	524,090,407.4	72,094,961.7
Барилга, байгууламж, орон сууц	345,579,085.3	401,985,267.0	56,406,181.7
Авто-тээврийн хэрэгсэл	2,335,162.7	2,400,100.4	64,937.8
Машин тоног төхөөрөмж (компьютер)	37,098,212.4	41,604,556.7	4,506,344.3
Тавилга, аж ахуйн эд хогшил	15,515,592.7	19,152,000.9	3,636,408.2
Зам, гүүрний байгууламж	703,094.5	1,348,739.9	645,645.5
Түүх соёл, музейн дурсгалт зүйлс	33,285,110.3	34,445,967.3	1,160,856.9
Бусад үндсэн хөрөнгө	7,409,473.4	12,928,080.6	5,518,607.2
Дуусаагүй барилга, байгууламж	1,838,527.6	1,777,072.6	(61,455.0)
Ном	8,231,186.9	8,448,622.1	217,435.1
Биет бус хөрөнгө	17,578,818.5	18,125,412.4	546,593.9
Программ хангамж	385,778.5	357,430.1	(28,348.4)
Бусад биет бус хөрөнгө	17,193,039.9	17,767,982.3	574,942.3
Дүн	496,145,699.4	571,803,944.4	75,658,245.0

Нийт хөрөнгийн эхний үлдэгдэл 496,145.7 сая төгрөг байснаас тайлант хугацааны эцэст 571,804.0 сая төгрөг болж 75,658.2 сая төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

Үндсэн хөрөнгийн өсөлтөд барилга байгууламж, орон сууц 56,406.2 сая төгрөг, бусад үндсэн хөрөнгө 5,518.6 сая төгрөг, машин тоног төхөөрөмж (компьютер) 4,506.3 сая төгрөг, тавилга, аж ахуйн эд хогшил 3,636.4 сая төгрөг, Түүх соёл, музейн дурсгалт зүйлс 1,160.9 сая төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн. Тухайлбал: Төрийн Өмчийн бодлого

зохицуулалтын газрын 2025 оны 704 дүгээр тогтоолын дагуу Баян-Өлгий аймгийн Толбо сумын 300 хүний суудалтай Соёлыг төвийн барилга 2,763.1 сая төгрөг, Булган аймгийн Булган сумын Төв номын сангийн барилга 2,940.2 сая төгрөг, Говь-Алтай аймгийн Халиун сумын 250 хүний суудалтай Соёлын төвийн барилга 3,153.7 сая төгрөг, Завхан аймгийн Түдэвтэй сумын 200 хүний суудалтай Соёлын төвийн барилга 2,079.8 сая төгрөг, Өвөрхангай аймгийн Хужирт сумын Соёлын төвийн барилга 3,950.3 сая төгрөг, Өмнөговь аймгийн Даланзадгад сум, Аймгийн номын сангийн барилга 4,159.2 сая төгрөг, Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Соёлын төвийн барилга 2,923.0 сая төгрөг, Хэнтий аймгийн Мөрөн сумын 240 хүний суудалтай Соёлын төвийн барилга 2,519.3 сая төгрөг, Увс аймгийн Зүүнхангай сумын Соёлын төвийн өргөтгөл, шинэчлэл 914.9 сая төгрөгөөр тус тус үндсэн хөрөнгөөр бүртгэх зөвшөөрөл олгож, бүртгэсэнтэй холбоотой байна.

Харьяа байгууллагуудын илрүүлэлт:

- Хуримтлагдсан элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн үндсэн хөрөнгүүдийн үнэ болон ашиглах хугацааг шинэчлэн тогтоолгоогүй. /Нийслэлийн Соёл урлагийн газар 243.3 сая төгрөг, Булган аймгийн хөгжимт жүжгийн театр 413.9 сая төгрөг, Хангал сумын Соёлын төв 41.9 сая, төгрөг Булган сумын Соёлын ордон 69.6 сая төгрөг, Завхан аймгийн Цэцэн-Уул сумын Соёлын төв 76.1 сая төгрөг, Цагаанхайрхан сумын Соёлын төв 78.8 сая төгрөг, Дундговь аймгийн Дэлгэрцогт сумын Соёлын төв 17.6 сая төгрөг, Төв аймгийн Бүрэн сумын Соёлын төв 1.9 сая төгрөг, Сэлэнгэ аймгийн Хушаат сумын Соёлын төв 9.7 сая төгрөг, Баянхонгор аймгийн Хөгжимт драмын театр, Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Соёлын төв, Мандал-Овоо сумын Соёлын төв.../
- Үндсэн хөрөнгийн түүвэр тооллогоор бөөн дүнгээр бүртгэсэн. /Өмнөговь аймгийн Гурвантэс сумын Соёлын төв 10.6 сая төгрөг, Цогтцэций сумын Соёлын төв 1.9 сая төгрөг/
- Жилийн эцсийн тооллого хийгээгүй. /Булган аймгийн Дашинчилэн сумын Соёлын төв 697.8 сая төгрөг, Дундговь аймгийн Цагаандэлгэр сумын Соёлын төв 30.5 сая төгрөг, Ховд аймгийн Цэцэг сумын соёлын төв 14.3 сая төгрөг, Чандмань сумын соёлын төв 9.8 сая төгрөг, Өвөрхангай аймгийн Есөнзүйл сумын Соёлын төв 2.3 сая төгрөг, Нийслэлийн Соёл урлагийн газар, Өмнөговь аймгийн Номгон сумын Соёлын төв, Мандал-Овоо сумын Соёлын төв, Ноён сумын Соёлын төв, Ханхонгор сумын Соёлын төв.../
- Өвөрхангай аймгийн төв номын сан эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр 68.8 сая төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг тогтоож, ашиглалтын хугацааг сунгасан;
- Архангай аймгийн Өлзийт сумын Соёлын төвийн үндсэн хөрөнгийг ангиллын дагуу бүртгэсэн эсэхийг хянаж үзэхэд тавилга эд хогшлын дансанд хамааралгүй 21.6 сая төгрөгийн машин тоног төхөөрөмж, 0.3 сая төгрөгийн бараа материалыг буруу бүртгэсэн;
- Ховд аймгийн хөгжимт драмын театр жүжгийн зохиол, хөгжмийн зохиол, найруулга, бүжиг дэглэлт, хоолойн бичлэг зэрэг хөлсөөр хийгдэж байгаа биет бус хөрөнгийн шинж чанартай зардлыг нягтлан бодох бүртгэлд бүртгэх талаар НББББ-т тодорхой заагаагүйгээс 16.5 сая төгрөгийг шууд зардалд бүртгэж тайлагнасан;
- Ховд аймгийн Алтай сумын соёлын төв үндсэн хөрөнгө орлого авахдаа санхүүгийн программд ашиглах жил оруулаагүйтэй холбоотой 3 нэр төрлийн 5.9 сая төгрөгийн хөрөнгөд элэгдэл тооцоогүй байна.

Программ хангамжийн бүртгэл: Соёл урлагийн газрын харьяа байгууллагуудын 408 газар Санхүүгийн тооцоолох программ Acolous, санхүүгийн бүртгэл хөтлөх динамик программ (moc.dynamic.mn),-ууд нь 292.1 сая төгрөг, 52 газар ашиглаж байгаа номын сангийн программ 58.6 сая төгрөг, 24 газар ашигладаг архивын программ 33.0 сая төгрөг, 6 газар ашиглаж байгаа дуу бичлэгийн программ 15.6 сая төгрөг, нийт 399.3 сая төгрөгийн программуудыг тус тус ашиглаж байна.

3.4.6 Өр төлбөр

Өр төлбөр дансны эцсийн үлдэгдэл 1,176.4 сая төгрөг болж өмнөх оноос 726.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Ажилчидтай холбогдсон өглөг	113,447.4	250,548.9	137,101.6
Бараа үйлчилгээний зардлын өглөг	106,918.8	222,726.2	115,807.6
Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг	1,068.0	1,066.9	(1.0)
Бусад өглөг	228,171.9	699,083.2	470,911.3
Татаас санхүүжилтийн шилжүүлгийн өглөг		2,947.8	2,947.8
Дүн	449,606.1	1,176,371.1	726,765.0

Нийт өр төлбөр өсөхөд бусад өглөг 470.9 сая төгрөг, ажилчидтай холбогдсон өглөг 137.1 сая төгрөг, бараа үйлчилгээний зардлын өглөг 115.8 сая төгрөг, татаас санхүүжилтийн шилжүүлгийн өглөг 2.9 сая төгрөгөөр тус тус голлон нөлөөлсөн. Тухайлбал: Өр төлбөр дансны ажилчидтай холбогдсон өглөг нь өмнөх оноос 137.1 сая төгрөгөөр өссөн нь тэтгэвэр, тэтгэмжийн санхүүжилт зарцуулах эрх нээгдээгүй, мөн засгийн газрын цомхотголтой холбоотой цалингийн сан батлагдсан төсвөөс бага дүнгээр буурч орж ирсэн. Татаас санхүүжилтийн өглөг нь ахмадын сангийн авлага, өглөгийн санхүүжилтийн зарцуулах эрх нээгдээгүйн улмаас санхүүжилт олгоогүйтэй холбоотой байна.

Харьяа байгууллагуудын илрүүлэлт:

- Өр төлбөр дансны үлдэгдлийг тооцоо нийлж тулган баталгаажуулаагүй. /Дархан-Уул аймгийн залуучууд театр 27.7 сая төгрөг, Хөвсгөл аймгийн Алаг-Эрдэнэ сумын Соёлын төв 3.4 сая төгрөг, Ховд аймгийн Булган сумын соёлын төв 1.6 сая төгрөг, Дорноговь аймгийн Сайхандулаан сумын Соёлын төв 0.3 сая төгрөг/;
- Төсөв байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд нягтлан бодох бүртгэлээр тавих хяналт сул байгаагаас тайлант онд шинээр өглөг үүссэн. /Алаг-Эрдэнэ сумын Соёлын төв 2.3 сая төгрөг, Булган аймгийн төв номын сан 3.4 сая төгрөг, Хялганат сумын Соёлын төв 2.2 сая төгрөг, Төв аймаг Монгол туургатан театр 48.8 сая төгрөг, Төв аймгийн Борнуур сумын Соёлын төв 0.7 сая төгрөг/;
- Олон жил болсон насжилт өндөр, он дамжсан данс бүртгэлд тусгасан өр төлбөрийг барагдуулаагүй. /Соёл урлагийн газар 1.9 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн Булган сумын соёлын төв 1.4 сая төгрөг /.

3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны дүн нь 74,931.48 сая төгрөгөөр нэмэгдэж 570,627.57 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Б	1	2	3=2-1
Засгийн газрын хувь оролцоо	495,696,093.4	570,627,573.3	74,931,479.9
Хуримтлагдсан үр дүн	271,780,231.3	348,874,559.2	77,094,327.9
Өмнөх үеийн үр дүн	220,427,999.5	274,335,885.7	53,907,886.2
Тайлант үеийн үр дүн	51,352,231.8	74,538,673.5	23,186,441.7

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 570,627.5 сая төгрөг болж, 74,931.4 сая төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-т заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2025 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 198,207.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна. Төсвийн төслийн саналаас бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийг 1,030.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж, цалин, хөлс болон нэмэгдэл урамшуулал 20,060.1 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 2,150.3 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 37.5 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал 124.1 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардал 80.0 сая төгрөг, томилолт зочны зардал 195.0 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 4,772.8 сая төгрөг, урсгал шилжүүлэг 5,176.8 сая төгрөг, нийт 31,566.8 сая төгрөгийн зардлыг бууруулж, 166,640.7 сая төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 13 арга хэмжээр санхүүжүүлэхээр улсын төсвөөс 166,640.7 сая төгрөгийн санхүүжилт батлагдаж, гүйцэтгэлээр 166,640.7 сая төгрөгийн санхүүжилт авч, 161,225.5 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 161,225.5 сая төгрөг буюу 96.75 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлаас 2,935.0 сая төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал дэмжлэгээс 319.4 сая төгрөг, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгэлдүүлэх 986.8 сая төгрөг, Театр, чуулгад гүйцэтгэлээр олгох санхүүжилт 247.9 сая төгрөг, Нүүдэлчин дэлхийн соёлын фестивалд 82.5 сая төгрөг, Улсын их баяр наадмын зардлаас 2.7 сая төгрөг, Уран бүтээл хийлгэх зардлаас 696.5 сая төгрөг, Эрдэм шинжилгээ, судалгааны ажлын зардлаас 126.9 сая төгрөг тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

3.5.3 Хөтөлбөр, арга хэмжээний хүрэх үр дүн, хэрэгжилт

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хавсралтаар баталсан тус төсвийн ерөнхийлөн захирагчийн тайлант онд хэрэгжүүлэх хөтөлбөр, 13 хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүнгийн зорилтот түвшнийг тусгажээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

Код	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	149,084,266.3	146,149,219.2	2,935,047.1	98.0%
80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	4,121,530.7	3,802,113.1	319,417.6	92.3%
81569	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	1,678,208.1	691,339.8	986,868.3	41.2%
81855	Гүйцэтгэлд суурилсан санхүүжилт	4,800,000.0	4,552,008.4	247,991.6	94.8%
81908	Түүх, соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах	24,000.0	24,000.0	-	100.0%
81919	Оны шилдэг уран бүтээлч найруулагч жүжигчин зураач бүжигчдийг шагнах	75,000.0	75,000.0	-	100.0%
81938	Музейн үзмэртэй шууд харьцах албан тушаалтанд төрөөс үзүүлэх дэмжлэг	16,800.0	16,800.0	-	100.0%
81952	Нүүдэлчин дэлхийн соёлын фестиваль	3,000,000.0	2,917,523.1	82,476.9	97.3%
82801	Улсын их баяр наадам	1,500,000.0	1,497,280.1	2,719.9	99.8%
83603	Нэмэлт - Дээд шатны төсвөөс хуваарилсан	17,117.5	-	17,117.5	0.0%
80214	Уран бүтээл хийлгэх	1,978,750.0	1,282,201.0	696,549.0	64.8%

80215	Эрдэм шинжилгээ, судалгааны ажил	345,000.0	218,033.7	126,966.3	63.2%
Дүн		166,640,672.6	161,225,518.4	5,415,154.2	96.8%

Төрийн аудитын байгууллагаас Төсвийн тухай хуулийн дагуу хийх 2025-2026 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитад баримтлах ерөнхий чиглэлийн дагуу судалгаа авч үр дүнг нэгтгэн дүгнэлээ. Үүнд:

Бүтэц орон тоо: Соёл урлагийн газрын харьяа байгууллагуудын 2025 оны батлагдсан цалингийн сан 131,499.7 сая төгрөг буюу 4669 орон тоотой, гүйцэтгэлээр 128,817.9 сая төгрөг буюу 4718 албан хаагчтай ажилласан байна. Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 05 дугаар сарын 20-ны өдрийн 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар Соёл урлагийн газрыг 41 орон тоотой байхаар тогтоосон байна. Соёл урлагийн газрын харьяа байгууллагуудын бүтэц, орон тоог оновчтой, үр ашигтай байх зарчимд нийцүүлэн шинэчлэн тогтоож, төрийн захиргааны байгууллагын зарим чиг үүргийг гэрээгээр гүйцэтгүүлэх, цахим технологийг нэвтрүүлэх замаар төрийн албан хаагчийн тоог бууруулах арга хэмжээний хүрээнд батлагдсан орон тоог 4-өөр бууруулж 4 газар, 2 хэлтэстэй байхаар бүтэц, зохион байгуулалттай ажиллахаар төлөвлөсөн байна. Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газраас 2025 оны 12 дугаар сарын 10-ны өдрийн 01/1204 бичгээр чиг үүргийн шинжилгээ хийх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулах албан бичгийг ирүүлсний дагуу бүтэц зохион байгуулалт, орон тоо, чиг үүргийн мэдээллийг хүргүүлсэн байна.

Унаа, хоолны хөнгөлөлт: Соёл урлагийн газрын даргын 2024 оны 11 дүгээр сарын 28-ны өдрийн А/87 дугаар тушаалаар ажлын нэг өдрийн унаа, хоолны хөнгөлөлтийг 34,000 төгрөгөөр тогтоосон байна. Судалгаагаар орон нутгийн соёлын харьяа байгууллагууд албан хаагчдад журмын дагуу хоол, унааны хөнгөлөлт олгодог боловч хоолны хөнгөлөлт 4,000-30,000 төгрөг, унааны хөнгөлөлт 400-3000 төгрөгөөр тус тус ялгаатай олгож байна. Соёлын харьяа байгууллагуудын 2025 оны хоол, унааны хөнгөлөлтийн батлагдсан төсөв 3,246.5 сая төгрөг, гүйцэтгэлээр 3,830.0 сая төгрөг байгаа нь цалингийн сангаас хоол унааны зардал гаргаж зарцуулсан байна.

Шүүхийн шийдвэрээр төрд үчруулсан хохирол: Тайлант онд судалгаагаар Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театр нь 2 албан хаагчийн ажилгүй байсан хугацааны цалин хөлсний олговор 42.2 сая төгрөг, Дундговь аймгийн Төв номын сан нь 1 албан хаагчид 5.3 сая төгрөг, Говь-алтай аймгийн Чуулга 2 албан хаагчид 44.5 сая төгрөг, Жангар номын сан нь 1 албан хаагчид 2.2 сая төгрөг, Бигэр сумын Соёлын төв нь 1 албан хаагчид 4.3 сая төгрөг, нийт 98.5 сая төгрөгийн шүүхийн нэхэмжлэлтэй байна. Тайлант онд Говь-алтай аймгийн Бигэр сумын Соёлын төв нь 1.8 сая төгрөг барагдуулж, тухайн байгууллагын төсвөөс Говь -Алтай аймгийн Чуулга, Жангар номын сан нь 46.7 сая төгрөгийг олгож, зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, Дундговь аймгийн Төв номын сан нь 5.3 сая төгрөгийн авлага үүсгэсэн, Хөвсгөл аймгийн Хөгжимт драмын театр нь 42.2 сая төгрөгийг барагдуулаагүй шалтгаан тайлбарыг төсөв байхгүй гэжээ.

Гадаад албан томилолт: Гадаад албан томилолтын зардал төлөвлөөгүй боловч Соёлын сайдын 2025 оны А/3 тушаалаар Швейцарын Холбооны улсын Цюрих хотын Ритберг музейд зохион байгуулагдахаар төлөвлөж буй “Монгол Улс – Цаг хугацааны аялал” үзэсгэлэнгийн бэлтгэл ажлыг хэлэлцэх зорилгоор тийзийн зардал 5.7 сая төгрөгийг байгууллагын удирдлагад дотоод томилолтын зардлаас олгосон байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн

бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн санхүүжилт Засгийн газрын нөөц сан, Засаг даргын нөөц хөрөнгөөс 17 аймгийн соёл, урлаг, аялал жуулчлалын газарт 3,285.7 сая төгрөг, Соёлын байгууллагуудын үйл ажиллагааны орлогоос дээд шатны төсвийн захирагчийн төсөвт туссан хөрөнгөөс орон нутгийн 22 төсвийн захирагчид хуваарилсан 10,996.2 сая төгрөг, Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 62.0 сая төгрөг, нийт 14,343.8 сая төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлжээ.

Гүйцэтгэлээр цалин хөлс болон нэмэгдэл урамшил 922.6 сая төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 108.7 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 19.0 сая төгрөг, хангамж, бараа материалын зардал 193.5 сая төгрөг, норматив зардал 13.2 сая төгрөг, эд хогшил, урсгал засварын зардал 20.5 сая төгрөг, томилолт, зочны зардал 65.5 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 7,855.6 сая төгрөг, бараа үйлчилгээний бусад зардал 4,666.4 сая төгрөг, бусад урсгал шилжүүлэг 295.3 сая төгрөг, нийт 14,160.2 сая төгрөгийг зарцуулж, 183.6 сая төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөө батлагдаагүй болон гүйцэтгэлээр зардал гараагүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-т “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Соёл, урлагийн газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийсэн Соёл, урлагийн газар түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааг сайжруулах, дотоод хяналтын тогтолцоо, хүний нөөцийн удирдлага, санхүүгийн бүртгэл ба тайлагнал, төсвийн сахилга бат, батлагдсан бүтэц орон тоог нөхөх талаар өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Үндэсний аудитын газрын Санхүүгийн аудитын газрын ахлах аудитор Ш.Наран, аудитор Т.Нямсүрэн нар гүйцэтгэж, аудитын үе шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Эрдэнэцэцэг, газрын захирал, тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг нар тус тус хэрэгжүүлсэн.

Соёл, урлагийн газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Үндэсний аудитын газарт 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 01/123 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2025 оны төсвийн нийт зарлагын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг “дунд” гэж үнэлсэн.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2025 оны төсвийн нийт зарлагын дүнг 166,640.8 сая төгрөгөөс 1.0 хувиар буюу 1,666.4 сая төгрөгөөр тогтоосон бөгөөд гүйцэтгэлийн шатанд материаллаг байдлыг дахин хянаж, тайлант оны нэгтгэсэн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 209,501.9 сая төгрөгийн 1.0 хувиар буюу 2,095.0 сая төгрөгөөр тогтоож шинэчлэх, шаардлагатай гэж үзлээ.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Харьяа байгууллагуудын аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 19.6 сая төгрөгийн 6 зөрчил илэрсэнд 11.7 сая төгрөгийн 4 албан шаардлага, 7.9 сая төгрөгийн 2 зөвлөмж хүргүүлсэн байна.

Илрүүлэлт:

- Төсвийн хөрөнгөөр үндсэн хөрөнгийг бэлтгэхдээ цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй. /Баянхонгор аймгийн Соёл, урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар 1.7 сая төгрөг, Говьсүмбэр сумын Нийтийн номын сан 0.8 сая төгрөг, Дундговь аймгийн Музей 10.2 сая төгрөг, Баян-Өлгий аймгийн Булган сумын соёлын төв 5.9 сая төгрөг.../
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж төсвийн хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйл бэлтгэсэн. /Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын соёлын төв 0.7 сая төгрөг, Булган аймгийн Бүрэгхангай сумын соёлын төв 0.3 сая төгрөг.../

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

4.4.1.1 Харьяа байгууллагуудын аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2,907.7 сая төгрөгийн 59 зөрчил илэрсэнд 2,441.7 сая төгрөгийн зөрчилд 11 албан шаардлага, 296.0 сая төгрөгийн зөрчилд 3 хариуцлага тооцох албан шаардлага, 170.0 сая төгрөгийн 32 зөвлөмж хүргүүлсэн байна.

Илрүүлэлт:

- Шилэн дансны цахим хуудсанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байгууллагын дарга, нягтлан бодогчийн нэр зөрүүтэй, байгууллагын төсөв, өмч, хөрөнгө мөнгө зарцуулсан тушаал шийдвэр, 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын гүйлгээ мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан. /Өвөрхангай аймгийн Баян-Овоо сумын соёлын төв 7.5 сая төгрөг, Эрдэнэзуу музей 5.5 сая төгрөг, Хэнтий аймгийн Баян-Овоо сумын соёлын төв 113.5 сая төгрөг, Увс аймгийн номын сан 0.5 сая төгрөг, Сүхбаатар аймгийн угсаатны зүйн музей 0.9 сая төгрөг, Өмнөговь аймгийн хөгжимт жүжгийн театр 231.6 сая төгрөг, Ханбогд сумын Соёлын төв 32.4 сая төгрөг, Сэврэй сумын Соёлын төв 12.3 сая төгрөг, Баян-Овоо сумын Соёлын төв 131.1 сая төгрөг.. /
- Шилэн дансны цахим хуудсанд холбогдох мэдээллийг байршуулаагүй. /Нийслэлийн Соёл урлагийн газар 1,451.0 сая төгрөг, Дундговь аймгийн Эрдэнэдалай Соёлын төв 8.2 сая төгрөг, Луус сумын Соёлын төв 30.4 сая төгрөг, Орхон аймгийн Жаргалант сумын Соёл мэдээллийн төв, Төв аймгийн Угтаал сумын Соёлын төв... /
- Өмнөх аудитын илэрсэн зөрчил арилгаагүй, давтан гаргасан. /Дундговь аймгийн Төв номын сан 12.5 сая төгрөг, Цагаандэлгэр сумын Соёлын төв 129.0 сая төгрөг, Говьсүмбэр аймгийн Баянтал сумын соёлын төв 154.4 сая төгрөг... /

4.4.1.2 Төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлан:

Илрүүлэлт: Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой төсвийн гүйцэтгэлийн 18 мэдээлэл, хөрөнгө оруулалт тендер худалдан авалтын 1 мэдээлэл, нийт 19 мэдээлэл хугацаа хоцроосон зөрчилд 1 зөвлөмж хүргүүлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-т “мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх”, 4.1.2-т “мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх”, 4.1.3-т “тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6.1.2-т “хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор, өмнөх оны төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, сар, улирлын гүйцэтгэлийг дараа сарын 08-ны өдрийн дотор” гэж заасантай тус тус нийцээгүй байна

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хуулийн хугацааг мөрдөж ажиллаагүй зөрчлийг давтан гаргахгүй байх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

4.4.2.1 Харьяа байгууллагуудын аудитаар бусад хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой 6,230.8 сая төгрөгийн 35 зөрчил илэрсэнд 0.3 сая төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,235.4 сая төгрөгийн 19 албан шаардлага, 3,995.1 сая төгрөгийн 29 зөвлөмж хүргүүлсэн байна.

Илрүүлэлт:

- Соёлын байгууллагын 5 жил тутамд нэг удаа олгох мөнгөн тэтгэмжээс хувь хүний орлогын албан татвар суутган тооцоогүй. /Дорнод аймгийн хөгжимт драмын театр 4.7 сая төгрөг/
- Байгууллагын биет бус хөрөнгөд бүртгэлтэй газар нь үндсэн хөрөнгийн бүртгэл, газар эзэмших эрхийн гэрчилгээ болон цахим санд (egazag.gov.mn)-д зөрүүтэй бүртгэсэн. /Баянхонгор Богд сумын Соёлын төв, Баян-Өндөр сумын Соёлын төв, аймгийн Нийтийн номын сан/
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг зөрчсөн. /Соёл урлагийн газар 1,438.2 сая төгрөг, Дундговь аймгийн Өлзийт сумын Соёлын төв 0.4 сая төгрөг, Завхан аймгийн Асгат сумын Соёлын төв 0.8 сая төгрөг, Б.Явуухулангийн нэрэмжит төв номын сан 6.6 сая төгрөг.../
- Соёл урлагийн газрын даргын 2023 оны А/13 дугаар "Агентлагийн ажлын байрны нэр, ангилал, зэрэглэл шинэчлэн батлах тухай" тушаал, А/21 дугаар "Газрын орон тоо, албан хаагчдын тушаалын цалин шинэчлэн тогтоох тухай" тушаалаар алба хаагчдын цалин, нэмэгдлийг батлан ажиллаж, одоог хүртэл шинэчлээгүй;
- Соёл урлагийн газрын бүтэц орон тоог 3 газар, 4 хэлтэстэй байхаар баталж, үйл ажиллагаа явуулдаг бөгөөд тайлант хугацаанд нийт 12 төрийн албан хаагчийг мэргэжилтэн, хэлтэс, газрын даргын албан үүргийг 6 сараас дээш хугацаагаар түр орлон гүйцэтгүүлж байгаа нь хавсран гүйцэтгэж байгаа ажилтны ачаалал нэмэгдэж, ажлын чанар, үр дүн буурах мөн чиг үүргийн давхардал, хариуцлагын тодорхойгүй байдал үүсэж, дотоод хяналтгүй болох эрсдэлтэй;
- Дорнод аймгийн Баянтүмэн сумын Соёлын төвийн бүтэц орон тоо бууруулах арга хэмжээ авч ажиллаагүй;
- Өмнөх аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд нь хэрэгжүүлээгүй. /Булган аймгийн Могод сумын Соёлын төв/.

4.4.2.2. Төсвийн төвлөрүүлэн захирагч

Зөвлөмж:

Илрүүлэлт 1: Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулж, мөрдөж ажиллаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.2-т "аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулах, батлуулах, хэрэгжилтийг зохион байгуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг өөрсдийн хүчээр нэмэлт зардал гаргахгүйгээр боловсруулж, мөрдөж ажиллах.

Илрүүлэлт 2: Харьяа соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн хуваарилалт, зарцуулалт, хэрэгжилтийн үр дүнд төсвийн төвлөрүүлэн захирагч дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй болон "Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал"-д төвлөрүүлэн захирагчийн бүрэн эрх, оролцоо, хяналт, баталгаажуулалтын эрх хэмжээ тодорхой тусгагдаагүй, хуульд заасан хяналт хэрэгжүүлэх аргачлал, бодлого тодорхойгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4.1-т "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8–д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", Соёлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 22.1.3-т "соёлын статистик мэдээллийг нэгтгэн гаргаж, дүн шинжилгээ хийх", 22.1.6-т "соёлын салбарт хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээний хэрэгжилтийг зохион байгуулах" гэсэн заалтуудад тус тус нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Харьяа соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан нэмэлт санхүүжилтийн хуваарилалт, зарцуулалт, хэрэгжилтийн үр дүнд тавих дотоод хяналтыг сайжруулах, мөн "Соёлын байгууллагуудын үр дүнд суурилсан санхүүжилтийн аргачлал"-д төвлөрүүлэн

захирагчийн бүрэн эрх, оролцоо, хяналт, баталгаажуулалтын эрх хэмжээг тодорхой тусгуулах талаар дээд шатны байгууллагад санал хүргүүлэх, аргачлалыг мөрдөж ажиллах.

Илрүүлэлт 3: Соёл, урлагийн салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүргийг улсын хэмжээнд зохион байгуулах ажлын хүрээнд 7 хууль тогтоомжийг дагалдан гаргах 32 журмыг батлаагүй, эрх зүйн орчныг боловсронгуй болгоход харьяа, анхан шатны байгууллагаас санал боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх ажлыг бүрэн хэрэгжүүлээгүй, хяналт, хариуцлагын үр нөлөө бүхий тогтолцоо бүрдээгүй.

Энэ нь Соёлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1-т "Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага соёлын үйл ажиллагааны талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 22.1.1-т "соёлын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулах", Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Соёл, урлагийн газрын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний 1.1-т "Салбарын хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход харьяа, анхан шатны байгууллагаас санал боловсруулж, холбогдох байгууллагад хүргүүлэх" гэсэн заалтуудад нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эрх зүйн орчныг боловсронгуй болгоход харьяа, анхан шатны байгууллагаас санал боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх, хууль тогтоомжийг дагалдан гаргах 32 журмыг батлах талаар арга хэмжээ авч ажиллах, хяналт, хариуцлагын үр нөлөө бүхий тогтолцоог бүрдүүлэн ажиллах.

Илрүүлэлт 4: Соёлын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлд хяналт - шинжилгээ хийдэггүй, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг дээд шатны зорилтод түвшинд нийцүүлээгүй, төлөвлөлтийг бодлогын баримт бичигт чиглүүлээгүй, мөн төлөвлөсөн арга хэмжээ нь харилцан адилгүй, уялдаа холбоогүй ялгаатай байгаа нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа нэгдсэн удирдлагаар хангаж ажиллаагүй. Гүйцэтгэлийн тайланг 2 байгууллага ирүүлээгүй. Мөн орон нутгийн номын сан, музей, театр, чуулгын байгууллагын гүйцэтгэлийн тайланд хяналт -шинжилгээ, үнэлгээ хийгээгүй, хяналт хэрэгжүүлээгүй байна. Гүйцэтгэлийн тайланд хийсэн үнэлгээгээр үр дүн хангалтгүй 31 арга хэмжээ, үр дүн гараагүй 16 арга хэмжээ тус тус байна.

Энэ нь Монгол Улсын Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт "Хяналт-шинжилгээ хийх журам"-ын 4.2.4-т "журамд заасан үүргээ биелүүлээгүй, заасан хугацаанд тайланг хүргүүлээгүй байгууллага, албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх саналыг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх", 3 дугаар хавсралт "Байгууллагын үйл ажиллагаа, үр дүнг үнэлж дүгнэх журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1-т "Байгууллагын хяналт-шинжилгээний асуудал хариуцсан нэгж нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтэд хагас жил тутам, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөрийн хэрэгжилтэд жил тутам хяналт-шинжилгээ хийнэ", 2.5-т "Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг дүгнэхдээ энэ журмын 2.4-т заасан аргачлалын дагуу дүгнэж, дараах ангилалд шилжүүлэн тооцно" гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Соёлын байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний төсөлд хяналт шинжилгээ хийх, зорилтот түвшин, шалгуур үзүүлэлтийг дээд шатны зорилтод түвшинд нийцүүлэх, төлөвлөлтийг бодлогын баримт бичигтэй уялдуулах, гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулахдаа нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах, гүйцэтгэлийн тайланг бүрэн нэгтгэн, хангалтгүй болон үр дүн гараагүй 47 арга хэмжээний хэрэгжилтийг авч үнэлэх.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Соёл, урлагийн газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн завсрын үеийн санхүүгийн тайлангийн аудитаар байгууллага, түүний орчин, дотоод хяналт, дотоод аудитын талаар ойлголт олж авснаар эрсдэл тодорхойлж, аудитын ерөнхий стратегийг боловсруулсан.

Аудитад 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл, тодруулгууд, харьяа төсвийн захирагчийн санхүүгийн тайлан, ерөнхий дэвтэр, ерөнхий журнал, анхан шатны баримт, үйл ажиллагааны тайлан болон бусад шаардлагатай баримтуудыг хамруулна.

Соёл урлагийн газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа 1 байгууллагын 2025 оны III улирлын санхүүгийн тайланд завсрын аудит хийж, нийт 5,894.9 сая төгрөгийн илрүүлсэн алдаа, зөрчил илрүүлснээс 29.1 сая төгрөгийн алдааг залруулж, 16.0 сая төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоохоор, худалдан авах ажиллагаатай холбоотой 5,645.8 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгах давтан гаргахгүй байх албан шаардлага өгөхөөр төлөвлөж, 220.0 сая төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгч аудитаар илэрсэн асуудлын бүртгэлийг хөтөлж, шалгагдагч байгууллагад танилцуулж, хүргүүлсэн.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Соёл, урлагийн газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргаагүй, татгалзсан дүгнэлт өгсөн.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлыг анхаарал хандуулах шаардлагатай гэж үзлээ. Үүнд:

- Төсвийн төвлөрүүлэн захирагчийн харьяа байгууллагуудад тайлант жил шүүхийн шийдвэрийн дагуу ажилгүй байсан хугацааны нөхөн олговрыг цалингийн зардлаас олгосон, буруу шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтнаар төрд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэх арга хэмжээ аваагүй байна. Иймд харьяа байгууллагуудаас уг асуудлаар шүүхийн шийдвэр, холбогдох тушаал, мөнгөн шилжүүлгийн нотлох баримтыг бүрдүүлэн нэгтгэж Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд тусган, зөрчлийг арилгуулах чиглэлээр албан шаардлага хүргүүлэхээр шийдвэрлэв.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчийн нэгтгэсэн санхүүгийн тайланд буруу тусган илэрхийлсэн 186,914.2 сая төгрөгийн 6 алдааг залруулга хийлгэлээ. Үүнд:

- Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайланд эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дүнг 304.7 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайланд эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дүнг 1,099.2 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайланд эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дүнг 1,650.6 сая төгрөгөөр зөрүүтэй илэрхийлсэн;
- Нэгтгэсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайланд эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын дүнг 361.6 сая төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан;
- Нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд 169,154.3 сая төгрөг, нэмэлт санхүүжилтийн тайлан 14,343.8 сая төгрөгийн тайланг тус тус ирүүлээгүй, орхигдуулсан.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" заалттай нийцээгүй, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт 1-т "Санхүүгийн тайлангийн толилуулга", "нийцсэн ба зохистой байх" батламж мэдэгдлийг хангаагүй байна.

Аудитаар харьяа байгууллагуудын аудитаар мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой 3,104.2 сая төгрөгийн 74 алдаа, буруу тусган илэрхийлсэнтэй холбоотой 16,611.3 сая төгрөгийн 272 алдаа, математик тооцоололтой холбоотой 167.2 сая төгрөгийн 11 алдаа, нягтлан бодох бүртгэлийн бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой 101.3 сая төгрөгийн 18 алдаа, нийт 19,984.0 сая төгрөгийн 375 алдааг төсвийн шууд захирагчийн санхүүгийн тайланд залруулсан байна.

Соёл урлагийн газрын даргын харьяа байгууллагуудын санхүүгийн аудитын зөрчилтэй холбоотой нийт 6,057.9 сая төгрөгийн 528 зөрчил илэрсэнд 140.6 сая төгрөгийн зөрчилд 112 төлбөрийн акт тогтоож, 3,261.4 сая төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 166 албан шаардлага, 2,625.5 сая төгрөгийн 248 зөвлөмж өгч, 30.5 сая төгрөгийн 2 зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 426 байгууллагын тайлан нэгтгэгдсэнээс 313 байгууллагыг түүврийн аудитад хамруулж, 113 байгууллагад аудит хийж дүгнэлт гаргасан. Аудитаар "Өөрчлөлтгүй" санал дүгнэлт 100 байгууллагад өгч, Соёл урлагийн газрын дарга, Соёл урлагийн газар, Нийслэлийн Соёл урлагийн газар, Ховд аймгийн Мөст, Чандмань, Цэцэг сумдын Соёлын төв, Өмнөговь аймгийн Мандал-Овоо, Цогтцэций, Гурвантэс сумдын Соёлын төв, Орхон аймгийн Баян-Өндөр сумын Аялгуу соёлын төв, Эгшиглэн соёлын төв, Жаргалант сумын Соёл мэдээллийн төв, Завхан аймгийн Соёл урлагийн газар, Дундговь Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар -т "Хязгаарлалттай" санал дүгнэлт өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар илэрсэн залруулагдаагүй нийт 6,057.9 сая төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан байгаа тул "Хязгаарлалттай" дүгнэлт өглөө.

5.1 Төсвийн төвлөрүүлэн захирагч

5.1.1 Албан шаардлага

Илрүүлэлт: Тайлант онд Соёл урлагийн газрын даргын харьяа байгууллагуудад хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6,057.9 сая төгрөгийн 528 зөрчил, нийцлийн асуудалтай холбоотой 9,138.6 сая төгрөгийн 101 зөрчил илэрсэн нь харьяа байгууллагуудын санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт хангалтгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.4-д "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг 30.0 хувиас доошгүй бууруулах арга хэмжээг авч ажиллах, дотоод хяналтыг сайжруулах албан шаардлага хүргүүлэв.

Дээрх шийдвэрийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 12 дугаар сарын 01 - ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Аймаг	Алдаа														Залруулаагүй алдаанд өгсөн шийдэл
		Нэгтгэсэн алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсантай холбоотой		Буруу тусган илэрхийлсэнтэй холбоотой		Математик тооцоололтой холбоотой		Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг буруу хэрэгжүүлсэнтэй холбоотой		Үүнээс:				
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	15
I. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ																
1	Соёл урлагийн газар дарга	6	3,599,598.1	2	183,498.1	4	3,416,100.0					6	3,599,598.1			
	Дүн	6	3,599,598.1	2	183,498.1	4	3,416,100.0	0	-	0	-	6	3,599,598.1	-	-	-
II. ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД																
1	Архангай аймаг	1	70,813.4		-	1	70,813.4				-	1	70,813.4			
2	Баян-Өлгий аймаг	14	647,629.0	3	311,743.6	11	335,885.4	0		-	0	14	647,629.0			
3	Баянхонгор аймаг	13	168,925.3	7	15,991.0	4	147,844.7	2	5,089.5			13	168,925.3			
4	Булган аймаг	23	297,442.8	-		12	172,490.0	3	103,089.4	8	21,863.4	23	297,442.8			
5	Говь-Алтай аймаг	12	356,371.2	4	304,649.1	7	33,042.1	-		-	1	18,680.0	12	356,371.2		
6	Говьсүмбэр аймаг	12	331,200.0			12	331,200.0					12	331,200.0			
7	Дархан-уул аймаг	4	157,872.3	2	1,851.3	2	156,021.0					4	157,872.3			
8	Дорноговь аймаг	33	736,506.0	8	261,313.7	20	443,145.4	2	6,136.3	3	25,910.6	33	736,506.0			
9	Дорнод аймаг	7	692,645.7	4	591,527.8	2	99,977.7			-	1	1,140.2	7	692,645.7		
10	Дундговь аймаг	28	201,923.2	6	80,714.5	21	118,405.7	1	2,802.9	0		28	201,923.2			
11	Завхан аймаг	17	253,101.9	6	51,640.6	11	201,461.2					17	253,101.9			

12	Орхон аймаг	9	235,482.5	2	15,492.7	6	196,966.9		-	1	23,023.0	9	235,482.5			
13	Өвөрхангай аймаг	7	72,399.0	1	1,533.8	6	70,865.2		-		-	7	72,399.0			
14	Өмнөговь аймаг	42	471,988.5	3	113,302.5	39	358,686.0	0	-	0	-	42	471,988.5			
15	Сүхбаатар аймаг	17	150,978.9	3	27,652.6	13	121,856.2	1	1,470.0		-	17	150,978.9			
16	Сэлэнгэ аймаг	0	-		-		-		-		-	0	-			
17	Төв аймаг	24	319,697.5	6	38,073.2	16	274,389.6	0	-	2	7,234.7	24	319,697.5			
18	Увс аймаг	11	314,101.8		-	11	314,101.8		-		-	11	314,101.8			
19	Ховд аймаг	52	904,814.5	14	272,873.6	34	579,873.4	2	48,577.5	2	3,490.0	52	904,814.5			
20	Хөвсгөл аймаг	9	47,617.0		-	9	47,617.0		-		-	9	47,617.0			
21	Хэнтий аймаг	28	253,049.3	3	772.0	25	252,277.3		-		-	28	253,049.3			
22	Нийслэл	11	13,270,377.3	2	1,015,081.8	9	12,255,295.5		-		-	11	13,270,377.3			
23	Соёл урлагийн газар	1	29,120.5		-	1	29,120.5		-		-	1	29,120.5			
Дүн		375	19,984,057.5	74	3,104,213.9	272	16,611,336.0	11	167,165.7	18	101,341.9	375	19,984,057.5	-	-	-
Нийт дүн		381	23,583,655.6	76	3,287,712.0	276	20,027,436.0	11	167,165.7	18	101,341.9	381	23,583,655.6	-	-	-

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

№	Аймаг	Санхүүгийн тайлангийн аудитын зөрчил													
		Нийт зөрчил			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн асуудал	
		Тоо	Дүн	Хүний тоо	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хүний тоо	Тоо	Дүн
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
I. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ															
1	Соёл урлагийн газар дарга	1					1								
	Дүн	1	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-
II. ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД															
1	Архангай аймаг	25	92,583.4	-	8	9,500.6	17	83,082.9		-		-			
2	Баян-Өлгий аймаг	10	44,080.6	-	5	11,997.7	-	-	5	32,082.9	-	-	-		
3	Баянхонгор аймаг	24	88,795.5	1	2	2,503.9	14	70,973.2	7	15,318.4	1	-	1		
4	Булган аймаг	39	1,421,787.8	-	9	9,556.1	5	707,123.2	25	705,108.4		-			
5	Говь-Алтай аймаг	43	160,954.6	-	1	2,123.5	4	9,336.6	38	149,494.5	-	-	-		
6	Говьсүмбэр аймаг	8	7,502.8	-	2	72.9	1	-	5	7,429.8		-			
7	Дархан-уул аймаг	11	74,430.7	-	2	5,630.4	2	4,988.1	7	63,812.2		-			
8	Дорноговь аймаг	29	71,404.3	-	6	7,891.8	7	17,580.1	16	45,932.4		-			
9	Дорнод аймаг	28	149,307.3	-	6	17,536.2	10	13,972.2	12	117,798.9		-			
10	Дундговь аймаг	21	75,089.0	1	5	6,047.7	13	20,879.3	2	17,648.3	1	30,513.6	1		
11	Завхан аймаг	29	154,874.5	-	10	4,710.8	14	43,392.0	5	106,771.7	-	-	-		
12	Орхон аймаг	46	220,947.3	-	17	10,930.0	12	202,574.4	17	7,443.0		-			

13	Өвөрхангай аймаг	12	100,150.0	-		-	9	31,376.7	3	68,773.3		-			
14	Өмнөговь аймаг	35	187,982.2	-	5	9,391.3	11	79,988.9	19	98,602.0	-	-			
15	Сүхбаатар аймаг	11	13,070.7	-	2	1,284.0	6	5,720.4	3	6,066.3		-			
16	Сэлэнгэ аймаг	6	158,712.7	-		-	3	6,095.0	3	152,617.7		-			
17	Төв аймаг	58	251,523.6	-	11	11,349.7	17	93,186.4	30	146,987.4		-	-		
18	Увс аймаг	5	4,768.9	-	2	1,507.5	2	1,955.9	1	1,305.5		-			
19	Ховд аймаг	31	98,914.6	-	7	18,204.9	1	3,196.0	23	77,513.8		-			
20	Хөвсгөл аймаг	23	107,007.6	-	3	1,484.0	2	5,625.0	18	99,898.6		-			
21	Хэнтий аймаг	18	229,804.4	-	8	6,900.2	9	222,904.2	1	-		-			
22	Нийслэл	6	1,032,549.9	-		-	2	612,114.0	4	420,435.9		-			
23	Соёл урлагийн газар	9	1,311,713.0	-	1	1,956.0	4	1,025,340.5	4	284,416.5		-			
Дүн		527	6,057,955.4	2	112	140,579.2	165	3,261,405.0	248	2,625,457.6	2	30,513.6	2	-	-
Нийт дүн		528	6,057,955.4	2	112	140,579.2	166	3,261,405.0	248	2,625,457.6	2	30,513.6	2	-	-

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

№	Аймаг	Нийцлийн аудитын зөрчил															
		Нийт зөрчил			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага			Хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн асуудал		Үүнээс Шилэн дансны хэрэгжилт	
		Тоо	Дүн	Хүний тоо	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хүний тоо	Тоо	Дүн	Тоо	Дүн /төгрөг/
А	Б	1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14	16	17
I. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ																	
1	Соёл урлагийн газар дарга	6					1		5							1	
	Дүн	6	-	-	-	-	1	-	5	-	-	-	-	-	-	1	
II. ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД																	
1	Архангай аймаг	0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
2	Баян-Өлгий аймаг	3	49,005.7	-	0	-	0	-	3	49,005.7	0	-	0	-	-	2	43,067.7
3	Баянхонгор аймаг	2	-	-	-	-	2	-	-	-	-	-	-	-	-	2	-
4	Булган аймаг	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	1	-
5	Говь-Алтай аймаг	0	-	-	0	-	0	-	0	-	0	-	0	-	-	0	-
6	Говьсүмбэр аймаг	5	169,511.6	1	0	-	3	15,066.9	1	-	1	154,444.7	1	-	-	-	-
7	Дархан-уул аймаг	1	217,947.0	-	-	-	1	217,947.0	-	-	-	-	-	-	-	-	-
8	Дорноговь аймаг	3	1,828,962.3	-	-	-	1	-	2	1,828,962.3	-	-	-	-	-	-	-
9	Дорнод аймаг	9	408,626.9	-	-	-	2	5,807.9	7	402,819.0	-	-	-	-	-	4	402,819.0
10	Дундговь аймаг	14	454,410.7	2	1	280.0	6	260,908.7	5	51,634.4	2	141,587.6	2	-	-	7	424,099.1

11	Завхан аймаг	1	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	-	1	-	
12	Орхон аймаг	3	-	-	-	1	-	2	-	-	-	-	-	-	-	-	
13	Өвөрхангай аймаг	15	130,743.6	-	-	2	12,982.3	13	117,761.3	-	-	-	-	-	14	125,283.6	
14	Өмнөговь аймаг	9	463,471.2	-	0	-	7	418,840.6	2	44,630.6	0	-	0	-	4	188,009.0	
15	Сүхбаатар аймаг	0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	
16	Сэлэнгэ аймаг	2	-	-	-	-	-	2	-	-	-	-	-	-	2	-	
17	Төв аймаг	11	342,612.4	-	0	-	1	-	10	342,612.4	0	-	0	-	13	-	
18	Увс аймаг	5	1,908,430.9	-	-	-	2	577,015.4	3	1,331,415.5	-	-	-	-	5	1,908.4	
19	Ховд аймаг	3	4,165.8	-	-	-	-	-	3	4,165.8	-	-	-	-	1	-	
20	Хөвсгөл аймаг	1	-	-	-	-	-	-	1	-	-	-	-	-	-	-	
21	Хэнтий аймаг	2	310,114.4	-	-	-	2	310,114.4	-	-	-	-	-	-	2	310,114.4	
22	Нийслэл	1	1,412,425.7	-	-	-	1	1,412,425.7	-	-	-	-	-	-	1	1,412,425.7	
23	Соёл урлагийн газар	4	1,438,172.4	-	-	-	2	1,438,172.4	2	-	-	-	-	-	-	-	
Дүн		95	9,138,600.5	3	1	280	34	4,669,281.2	57	4,173,007.0	3	296,032.3	3	0	0	59	2,907,726.9
Нийт дүн		101	9,138,600.5	3	1	280	34	4,669,281.2	63	4,173,007.0	3	296,032.3	3	0	0	60	2,907,726.9

6.4 Санхүүгийн тайлангийн аудитад хамрагдалт

№	Аймаг	Соёлын байгууллагын нийт тоо	Аудитын хэлбэр					
			Түүвэрт хамрагдсан байгууллагын тоо	Дүгнэлт өгсөн байгууллагын тоо	Үүнээс:			Дүгнэлт өгөхөөс татгалзсан
					Өөрчлөлтгүй	Хязгаарлалттай	Сөрөг	
I. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ								
1	Соёл урлагийн газар дарга	1		1		1		
Дүн		1		1		1		
II. ХАРЬЯА БАЙГУУЛЛАГУУД								
2	Архангай	22	18	4	4			
2	Баян-Өлгий	17	16	1	1			
3	Баянхонгор	24	20	4	4			
4	Булган	21	20	1	1			
5	Говь-Алтай	23	19	4	4			
6	Говьсүмбэр	6	4	2	2			
7	Дархан-уул	8	0	8	8			
8	Дорноговь	18	14	4	4			
9	Дорнод	18	16	2	2			
10	Дундговь	19	17	2	1	1		
11	Завхан	27	25	2	1	1		
12	Орхон	10	2	8	5	3		
13	Өвөрхангай	23	23	0				
14	Өмнөговь	18	1	17	14	3		
15	Сүхбаатар	16	15	1	1			
16	Сэлэнгэ	27	25	2	2			
17	Төв	31	28	3	3	0		

18	Увс	23		23	23			
19	Ховд	20	2	18	15	3		
20	Хөвсгөл	27	25	2	2			
21	Хэнтий	26	23	3	3			
22	Нийслэл	1		1		1		
23	Соёл урлагийн газар	1		1		1		
Дүн		426	313	113	100	13	-	-
Нийт дүн		427	313	114	100	14	-	-



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 1079/А0171109

Улаанбаатар хот

САГ - 2026/10/НА - СТА - ТТЗ

Зөрчил таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Соёл урлагийн газрын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Соёл урлагийн газрын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар санхүүтэй холбоотой илэрсэн нийт 6,057,955,399.90 (Зургаан тэрбум тавин долоон сая есөн зуун тавин таван мянга гурван зуун ерэн есөн төгрөг ерэн мөнгө) төгрөгийн 528 зөрчил, нийцлийн асуудалтай холбоотой нийт 9,138,600,476.65 (Есөн тэрбум нэг зуун гучин найман сая зургаан зуун мянга дөрвөн зуун далан зургаан төгрөг жаран таван мөнгө) төгрөгийн 101 зөрчил илэрсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.1-т "төсвийн тогтвортой байдлыг хангасан байх", 15 дугаар зүйлийн 15.4-т "Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ", 15.4.1-т "төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх", 16 дугаар зүйлийн 16.5.1-т "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах", гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө" Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг 30.0 хувиас доошгүй бууруулах арга хэмжээг авч, үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг сайжруулан, биелэлтийг 2026 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Соёл урлагийн газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Г.Батхуяг), Санхүү хэлтсийн дарга (Р.Дулмаа), Ерөнхий нягтлан бодогч (Б.Отгонжаргал) нарт даалгав.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР
АУДИТЫН МЕНЕЖЕР
АХЛАХ АУДИТОР
АУДИТОР

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

9006109
ATA16087
9025081411

Ц.НАРАНЧИМЭГ
И.ЭРДЭНЭЦЭЦЭГ
Ш.НАРАН
Т.НЯМСҮРЭН

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр,
Утас 51-264130

Z:\Alban Shaardlaga\2026\0325 SAG-12.Docx

1526181361